



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 16 өдөр

Дугаар А/584

Баруун-Урт сум

Түгээмэл тархацтай ашигт малтмалын
хайгуулын тусгай зөвшөөрөл цуцлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 35 дугаар зүйлийн 35.1.1, 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.2 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Асгат сумын нутаг “Ар цахилдаг” нэртэй 394.65 га, “Ар цахилдаг 1” нэртэй 397.22 га талбайд “Зэт Энд Эйч Юу” ХХК-д олгосон XV-22000011 (XV-22000002(2018/001), XV-22000012 (XV-22000003(2018/002) дугаартай түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг цуцалсугай.

2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон талбайг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Наранцэцэг), аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Ш.Нямхүү), Асгат сумын Засаг дарга (Ц.Гансүх) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Х.Энхцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ